

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газар



Аудитын код:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 70463612, 99058189 Цахим хаяг: zavkhan@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 70463783, 99019467 Цахим хаяг: khash_aud@yahoo.com



Аудитор: Г.Заяа

Утас: 70463783 Цахим хаяг: gotovzaya@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	9
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ..	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын гэрчилгээ

		ЗООНОЗ ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА Д.ДАШДАВАА -д
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 81000 Улиастай, Завхан аймаг Утас/Факс: 7046-36-12		
№	№	
2018.01.19	41	
танай	-ны №	-г
Аудитын гэрчилгээ		
<p>Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд 18.2 дахь заалтын дагуу Завхан аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийв.</p> <p>Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.</p> <p>Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.</p> <p style="text-align: center;">Санал дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p> <p>Аудитаар Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p> <p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.</p> <p style="text-align: center;">Зөрчилгүй санал дүгнэлт</p> <p>Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.</p>		
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Л.УЛАМБАЯР
		152 068

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Зооноз өвчин судлалын төвийн дарга Г. Дашдаваа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор *Зооноз өвчин судлалын төв-ийн 2017* оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017-01-15 -наас 2017-01-17 -ны хооронд хийж, аудитын тайланг 2017-01-19 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аудитор Г.Заяа хариуцаж хэрэгжүүлэв.

Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017-01-15-нд төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Зооноз өвчин судлалын төв “Манай хамт олон Байгалийн голомтот халдварт өвчний эрсдлийг бууруулах, мэдлэг чадварт суурилсан төрийн үйлчилгээний манлайлагч байгууллага байна” эрхэм зорилгын дор Эрүүл мэндийн газар-ийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Тайлант хугацаанд Зооноз өвчин судлалын төв “Зоонозын халдварт өвчнөөс хүн амыг урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх, лабораторит суурилсан тандалт судалгааг эрчимжүүлэх, халдвар эсэргүүцэх оновчтой зөв бодлого, зохицуулалтаар хангах” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Зооноз өвчин судлалын төв-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Зооноз өвчин судлалын төв-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

өөрчлөлт гараагүй

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Зооноз өвчин судлалын төв-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Зооноз өвчин судлалын төв санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “aculous” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Зооноз өвчин судлалын төв –ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгох нь тохиромжтой .

Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 268,1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 2,6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл багатай холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 7 эрсдэлтэй асуудалд 7 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэн 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	0.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	0.6	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал гараагүй

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Зооноз өвчин судлалын төв өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой урсгал зардалд 229,6 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	229,6	229,1	99,8	0,5
1.1	Урсгал зардал	229,6	229,1	99,8	0,5
1.2	Хөрөнгийн зардал	3,4	3,1	99,1	0,3
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	229,6	229,1	99,8	0,5
2.1	Улсын төсвөөс санхүүжих	229,6	229,1	99,8	0,5
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	0,5	0	-100	-0,5

Төсөвт зардлын гүйцэтгэл (99,8) хувь байгаа нь туслах үйл ажиллагааны орлого төвлөрөөгүйтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт (0) хувь байгаа нь орлогын төлөвлөгөө бодитой бус байгаатай холбоотой байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Зооноз өвчин судлалын төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Зооноз өвчин судлалын төв 2017-03-23-ны өдрийн 1/25 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид *Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.*

Зооноз өвчин судлалын төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь *Зооноз өвчин судлалын төвийн* нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

ЗАРДАЛ

Илрүүлэлт

- Тэтгэмж урамшуулын 0,4 сая төгрөгийн, төлбөр хураамжийн 0,2 сая төгрөгийн зардлыг төсөв батлагдаагүй гэсэн шалтгаанаар цалингийн, шатахууны, даатгалын зардалд тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Зооноз өвчин судлалын төвийн дарга
Г.Дашдаваа
Нягтлан бодогч Д.Мөнхнасан

Эрсдэл

Зардлын гүйцэтгэл буруу тайлагнагдах

Зөвлөмж

- Төсвийн төлөвлөлтийг бодитой болгох, төсөвт зохицуулалт хийх саналыг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлэх
-Төсөвт зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтанд үндэслэн үнэн зөв тайлагнах

-Өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 31-ны дотор албан тоотоор ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ
ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Л.УЛАМБАЯР	Огноо: 2018-01-18
АУДИТЫН МЕНЕЖЕР	Г.ХАШЦЭЦЭГ	Огноо: 2018-01-18

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР	Г.ЗАЯА	Огноо: 2018-01-18
---------	--------	-------------------

1.1 Асуудал 3: Зардал	1.2 Тэргүүлэх ач холбогдол №2
1.4 Асуудал 3: Зардал <u>ҮАГ-ынажиглалт</u>	1.5 Тэргүүлэх ач холбогдол №2 <u>ҮАГ-ын зөвлөмж</u>
Ундсан бус мэдээжилгээний 1.56 сая төгрөг, бусад орлогын 16.5 сая төгрөгийн орлогыг бууруулах бичилт	Төсвийн тухай үндсийг мөрдөж төсвийн үндсийн төлөвлөгөөг ойлгуулж ажиллах тэргүүлэх ач холбогдол №2

